



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Их эзэн Чингис хааны нэрэмжит талбай 1,
Төрийн ордон, Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreathural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2018. 06. 20 № 32

Асуулга тавих тухай


Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний тухай хууль батлагдан мөрдөгдөж эхэлснээс хойш 2 жил гаруй хугацаа өнгөрч байна. Гэтэл энэ хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т заасан “Иргэн өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн эмчээ сонгон бүртгүүлэхтэй холбогдох харилцааг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишигийн баталсан журмаар зохицуулна”, мөн хуулийн 3 дугаар болон 4 дүгээр бүлгүүдэд заасан олон заалт хэрэгжээгүй удааширч байна.

Иймд Монгол Улсын Их хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 -т заасныг үндэслэн Танд хандаж дараах асуулгыг тавьж байна. Үүнд:

1. Эмнэлгийн тусlamж үйлчилгээг иргэдэд чирэгдэлгүй хүргэх, чанар, хүртээмжийг дээшлүүлэх, эмнэлгийн ачааллыг бууруулах боломжийг бүрдүүлэхэд чиглэгдсэн дээрх хуулийн дагуу гаргаж мөрдөх журмуудыг хэрхэн боловсруулж, хуулийн заалтууд хэзээ бүрэн хэрэгжих нөхцөл бүрдэх талаар;
2. Иргэд цаг алдалгүйгээр өвчиний эрт илрүүлгийн оношилгоо, эмчилгээ хийлгэж чадаагүйн улмаас өвчин нь хүндэрч, улмаар гадаад оронд очиж оношуулах, эмчилгээ хийлгэхээр ихээхэн зардал, чирэгдэл учирч, хувь хүний болоод улс орны эдийн засагт хүндрэл учруулж байна. Иргэдэд учирч байгаа энэ хүндрэл бэрхшээлийг бууруулах талаар Эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар;
3. Иргэд эмнэлгийн байгууллага, эмчээ өөрөө сонгож үйлчлүүлэх нөхцөлийг бий болгоход чиглүүлж хийж байгаа ажлууд, үр дүнгийн талаар тус тус асуулга Танд хүргүүлж байна.

Асуулгын хариуг Монгол Улсын Их хурлын тухай хуульд заасан хугацаанд ирүүлж, Улсын Их Хурлын чуулганын нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэхийг Танаас хүсье.

УИХ-ын гишиг



М.Билэгт

Д.Тэнболд

Л.Энх-Амгалан

000000072